

ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ АВТОМАШИН, МЕХАНИЗМЫН 2020 ОНЫ ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ ТОС ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны автомашин, механизмын 2020 онд шаардлагатай тос тослох материалд тавигдах техникийн шаардлага болон нийт тоо хэмжээг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Эдгээр тос, тосолгооны материал нь автомашин, механизм, тоног төхөөрөмжийн тос, тосолгоо, хөргөлтийн зориулалтын байх бөгөөд Америкийн нэгдсэн улсын инженерүүдийн холбооны SAE, нефть судлалын хүрээлэнгийн API шаардлагыг хангасан байна.

2.1 Нийлүүлэгчид тавигдах шаардлага:

- 2.1.1 Нийлүүлэгч нь тухайн чиглэлээр нэгээс доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байна.
- 2.1.2 Нийлүүлэгч нь стандарт, шаардлагыг хангасан өөрийн агуулахтай байна.
- 2.1.3 Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүсэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцах, зөрчлийг арилгах чадамжтай байна.
- 2.1.4 Үйлдвэрлэгчийн болон нийлүүлэгчийн зүгээс чанарын баталгаа гаргана.
- 2.1.5 Тос тослох материалын техникийн үзүүлэлтийг харуулсан баримт бичгийг монгол хэл дээр ирүүлнэ.
- 2.1.6 Барааг өөрийн тээврийн хэрэгслээр эцсийн цэгт хүргэнэ.

2.2 Тос тослох материалд тавигдах шаардлага:

- 2.2.1 Өвөл болон зуны улиралд зориулсан мэдээллийг агуулсан тэмдэглэгээтэй байх.
- 2.2.2 Хөдөлгүүрийн эд ангийг бохирдолт, элэгдэл, исэлдлээс дээд зэргээр хамгаалсан байх
- 2.2.3 Ашиглалтын хугацаанд зунгаглаг шинж чанараа сайн хадгалдаг байх
- 2.2.4 Хэт хүйтэн болон халуун хэмд тослох шинж чанараа сайн хадгалдаг байх
- 2.2.5 4, 5, 20, 30, 200 литрийн багтаамжтай савалгаатай байж болох бөгөөд үйлдвэрийн лац, ломботой байх
- 2.2.6 2019 он эсвэл 2020 онд үйлдвэрлэгдсэн, шинэ байх

3. ТОС ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ТОО ХЭМЖЭЭ, ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Д/Д	Материалын нэр, марк	Техникийн шаардлага	Дүйцэх тос	Х/Н	Тоо хэмжээ
3.1	Тосол /орос/	Этилен гликол, хасах 40С ба түүнээс доош хэмд царцах	Siberia 40	кг	2005
3.2	Антифриз /улаан/	Этилен гликол, хасах 45С ба түүнээс доош хэмд царцах	Антифриз ультра улаан	кг	400
3.3	М8В бензин хөдөлгүүрийн тос /орос/	API SD/CB ба түүнээс дээш	Газпром нефть	л	800
3.4	М10ДМ дизель хөдөлгүүрийн тос /орос/	API CD ба түүнээс дээш	Газпром нефть	л	400
3.5	Гидрийн шингэн DTE10 EXCEL 15	ISO 15, хасах 45С ба түүнээс доош хэмд царцах	Mobil DTE10 EXCEL 15	л	1600
3.6	Гидрийн шингэн ВМГЗ /орос/	ISO 15, хасах 40С ба түүнээс доош хэмд царцах	Газпром нефть ВМГЗ	л	1200
3.7	Бензин хөдөлгүүрийн тос 5W30	API SL ба түүнээс дээш	Mobil Super 1000	л	1500
3.8	Дизель хөдөлгүүрийн тос 10W30	API CI-4 ба түүнээс дээш	Mobil Delvac MX	л	2500
3.9	Дизель хөдөлгүүрийн тос 15W40	API CI-4 ба түүнээс дээш	Mobil Delvac MX	л	3050
3.10	Механик хурдны хайцагны тос ТСП-15К /орос/	API GL-3 ба түүнээс дээш	Газпром нефть	л	400
3.11	Механик хурдны хайцагны тос 80W90	API GL-4 ба түүнээс дээш	Mobilube GX 80W90	л	600
3.12	Автомат хурдны хайцагны тос ATF WS	хасах 40С ба түүнээс доош хэмд царцах	Toyota ATF WS	л	80
3.13	Автомат хурдны хайцагны тос ATF SP-IV	хасах 40С ба түүнээс доош хэмд царцах	Hyundai ATF SP-IV	л	200
3.14	Автомат хурдны хайцагны тос ATF Dexron III	хасах 40С ба түүнээс доош хэмд царцах	Mobil Multipurpose ATF	л	500
3.15	Товуд EP-2	NGLI 1 эсвэл 2, хасах 30С ба түүнээс доош хэмд царцах	Mobilux EP2	кг	600

3.16	Шингэн товуд 000 эсвэл 0000	хасах 40С ба түүнээс доош хэмд царцах, төвийн тосолгооны системд	Kixx Super Grease EP000	кг	90
3.17	Тоормозны шингэн DOT-4	FMVSS 116 DOT 4	Mobil brake fluid DOT4	л	75